

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2027 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЭЛ, 2028-2029 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСӨЛТЭЙ ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ХЭЛЭЛЦЭХ
ЭСЭХ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ ТӨСВИЙН БОЛОН ЭДИЙН
ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 05 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч: Монгол Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хамтарсан хуралдаанаараа явууллаа.

Төсөл санаачлагч дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн огцом өөрчлөлт, геополитикийн нөхцөл байдал, инфляцын бодит өсөлт, мөнгөний бодлогын үндсэн чиглэл зэрэгт нийцүүлэн төсвийн тодотголын төслийг 3 сарын хязгаарлалтгүйгээр өргөн мэдүүлэх эрх зүйн боломжийг бүрдүүлэх, цаг алдалгүй төсвийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, мөн нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын буцаан олголтын 20 хувийг шаталсан хэлбэрээр нэмэгдүүлж 100 хүртэл хувьд хүргэх зохицуулалтыг хүчингүй болгож, 20 хүртэл хувийг буцаан олгохоор Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулсан байна.

Хуулийн төслүүдийг d.parliament.mn цахим сайтад байршуулж, иргэд, олон нийтийн саналыг авч байна.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар хуулийн төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн өрийг Засгийн газрын өрийн нийт дүнд тооцсон эсэх, Хуримтлалын санд төвлөрүүлэх төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн ногдол ашгийн хэмжээний талаар, Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжихгүй байгаагаа илэрхийлж, татварын буцаан олголтын шатлалыг бууруулснаар улсын төсөвт үзүүлэх нөлөөллийн талаар, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулснаар төсөвт тодотгол хийх боломж бүрдэх эсэх, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг Монгол Улсын 2026 оны төсвийн орлого бүрдүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт, мөн 2025 онд төсвийн орлогыг бүрдүүлэх зорилгоор урьдчилан төлүүлсэн татварын төлбөрийн дүнгийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаа иргэдийн амьдралын бодит нөхцөл байдалтай уялдуулан дунд хугацааны төсвийн төлөвлөлтөд инфляцыг хэрхэн тооцсон, гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтийг бууруулахаар хэрэгжүүлж байгаа арга

хэмжээний талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд инфляц, ажлын байр, ядуурлын түвшин, малчдын бодит орлогыг хэрхэн нэмэгдүүлэн тооцсон талаар болон Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төслийг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлтэй хэрхэн уялдуулсан талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг Засгийн газраас дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулахдаа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт, зөвлөмжийг тусгасан эсэх, энэхүү зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай эрх зүйн зохицуулалт байгаа эсэхийг тодруулж, эрчим хүч, боловсрол, эрүүл мэндийн салбараас бусад салбарын урсгал зардлыг бууруулахтай холбоотой санал Зөвлөлийн дүгнэлтэд тусгагдсан эсэх, улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бүрэн олгох боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал инфляцад нөлөөлж байгаа хүчин зүйлс болон инфляц нь иргэдийн худалдан авах чадвар, эдийн засгийн идэвхжилд хэрхэн нөлөөлж байгаа талаар, мөн махны бэлтгэн нийлүүлэлт, логистикийн тогтолцоог бий болгох, Евроазийн эдийн засгийн холбоо, Бүгд Найрамдах Узбекистан Улс болон Бүгд Найрамдах Солонгос Улстай байгуулах хэлэлцээрийн хүрээнд Монгол Улс, ялангуяа баруун бүсийн зах зээлийг тэлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээний талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах болсон үндэслэлийн талаар асуулт асууж, хариулт авлаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд төсвийн тогтвортой байдлыг хангах үндэслэлээр Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжих боломжгүй талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Пүрэвдаваа эдийн засгийн нөхцөл байдалд нийцүүлэн богино хугацаанд бизнесийн үйл ажиллагааг тогтворжуулах зорилгоор улирлын шинж чанартай жижиг, дунд бизнес эрхлэгчдийг татварын хөнгөлөлтөд хамруулах, том аж ахуйн нэгжүүдтэй Засгийн газар хэлэлцээр орох зэрэг асуудлыг тусгасан үнийн өсөлтийн төлөвлөгөөг боловсруулж ажиллахад анхаарах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай төсвийн зардлыг өсгөж, эдийн засгийн өсөлтийг өөдрөгөөр төсөөлсөн байгааг анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь үнийн өсөлттэй холбоотойгоор улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлын өсөлтийн зөрүүг 2027 оны төсөвт тусгахад анхаарч ажиллах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат хөрөнгө, санхүүжилт шаардахгүйгээр гүйцэтгэж болох асуудлын бодлого, төлөвлөлтийг гаргаж, боломжит хувилбар бүхий ажлуудыг хийж гүйцэтгэх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл, газрын тос боловсруулах үйлдвэр барих төслүүдийн гадаад зээлийн ашиглалтыг сайжруулахтай холбоотой хуулийн төслийг Улсын Их Хуралд дахин өргөн мэдүүлэх, өрхийн бодит орлогоос илүү зээлийн хэмжээ өсөж, ядуурал нэмэгдэж байгааг анхаарч арга хэмжээ авах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал эдийн засгийг идэвхжүүлэх, эдийн засаг дахь төрийн оролцоо, татварын ачааллыг бууруулж, хувийн хэвшлийг дэмжихэд чиглэсэн зарчмын өөрчлөлтүүд хийгдэхгүй байгааг анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Жаргалсайхан Монгол Улсын 2026 оны төсөвт зөвхөн багш нарын цалинг нэмэгдүүлэх санхүүжилтийг тусгаж баталсан байтал Засгийн газар хуулийг хэрэгжүүлэхдээ багш нарын цалинг нэмэхийн зэрэгцээ боловсролын байгууллагын ажиллагсдын цалинг давхар нэмэгдүүлж, төсөвт ачаалал үүсгэсэн, мөн түлш, эрчим хүчний томоохон төслүүдээ дуусгахад анхаарч ажиллах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөр Засгийн газраас гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, Оюу-Толгой төслийн

зээлийн хүүг бууруулах, гадаад бондын өрийн хэмжээг багасгах зэрэг эдийн засгаа тэлэх чиглэлээр арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж олон улсад хэрэгждэг сайн туршлага болох "Үдийн цай хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх нь бүх насны сурагчдын өсөлт, хөгжил, сурлагын амжилтад эерэг нөлөөлөл үзүүлдэг гэсэн судалгааны үр дүнд үндэслэн төсвийн хүрээний хязгаарт багтаан Монгол Улсын 2027 оны төсөвт энэ хөтөлбөрт шаардагдах зардлыг тусгах нь зүйтэй талаар тус тус санал хэлсэн болно.

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлаар санал хураалт явуулахад Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 56.4 хувийн саналаар, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 51.3 хувийн саналаар дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаас гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

